**МОНГОЛ УЛСЫН**
**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,**
**ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН**
**ТУШААЛ**

2018 оны 05 сарын 29 өдөр Дугаар А-101 Улаанбаатар хот

Төсөлд дэмжлэг үзүүлэх тухай

Засгийн газрын 2011 оны 374 дүгээр тогтоолоор баталсан "Мал хамгаалах сангийн хөрөнгийг захиран зарцуулах, тайлагнах журам"-ын 4.2, 4.3, 4.4 дэх заалт, Ажлын хэсгийн 2018 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн хурлын тэмдэглэл, мөн өдрийн дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Уураг тарималтэжээл тариалж тэжээлийн нөөц нэмэгдүүлэх төсөл сонгон шалгаруулалтад тэнцсэн аж ахуйн нэгжүүд, тэдгээрт олгох зээлийн хэмжээг хавсралтаар баталсугай.

2. Барьцаа хөрөнгийн шаардлага хангасан аж ахуйн нэгжтэй 5 жилийн хугацаатай, жилийн 3.6 хувийн хүүтэй, эхний жил үндсэн төлбөрөөс чөлөөлөх нөхцөлтэйгөөр зээлийн гэрээ байгуулж, зээлийн эргэн төлөлтөд хяналт тавьж ажиллахыг Мал хамгаалах сан /Ц.Цэдэндамбаа/-д даалгасугай.

3. Зээл олгоход шаардагдах 999.600.000 /есөн зуун ерэн есөн сая зургаан зуун мянга/ төгрөгийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2017 оны А-179 дүгээр тушаалын 2 дугаар хавсралтын 2.33-т заасан зардлаас санхүүжүүлэхийг Мал хамгаалах сан /Ц.Цэдэндамбаа/-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /М.Энх-Амар/-т үүрэг болгосугай.

САЙД Б.БАТЗОРИГ

Хүнс, хөдөө аж ахуй,
хөнгөн үйлдвэрийн Сайдын
2018 оны 05 дугаар сарын 09-ны
өдрийн А-101 дугаар тушаалын
хавсралт

## ТӨСӨЛ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАД ТЭНЦСЭН АЖ АХУЙН НЭГЖИЙН НЭР, ЗЭЭЛИЙН ХЭМЖЭЭ

| № | Аж ахуйн нэгжийн нэрс | Зээлийн хэмжээ /сая.төгрөг/ |
|---|---|---|
| 1 | "Аглаг талын уул" ХХК | 58,8 |
| 2 | "Мөнх цаст очирваань" ХХК | 58,8 |
| 3 | "Хүүлэй хааны хишиг" ХХК | 58,8 |
| 4 | "Хишлэг" ХХК | 58,8 |
| 5 | "Голден сойл" ХХК | 58,8 |
| 6 | "Сэжа" ХХК | 58,8 |
| 7 | "Энхцацагт консалтинг" ХХК | 58,8 |
| 8 | "Борнуур агро технологи" ХХК | 58,8 |
| 9 | "Хоргын хүү дэлгэрэх" ЗГБХНөхөрлөл | 58,8 |
| 10 | "Цохонт өндөр" ХХК | 58,8 |
| 11 | "Зон дэм" ХХК | 58,8 |
| 12 | "Ендрэнт" ХХК | 58,8 |
| 13 | "Мэнэн агро" ХХК | 58,8 |
| 14 | "Өлгий агро" ХХК | 58,8 |
| 15 | "Хишигтэн нүүдэлчин" ХХК | 58,8 |
| 16 | "Мөнхийн шанд" хоршоо | 58,8 |
| 17 | "Ар Эн Дистрибюшн" ХХК | 58,8 |
| НИЙТ | | 999,6 |